




Б. МАНДАХ



Б. НАРАНТУЯА

## СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ГЭРЭЭ

2017 оны 06 дугаар сарын ...

Дугаар... 2017.06.06.07.1

Улаанбаатар хот

### 1. Ерөнхий зүйл

Монгол Улсын Эрүүл мэндийн хөгжлийн төв (цаашид "ЭМХТ" гэх), Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотын "ПУНДААН ЧА" Төв Эмнэлгийн төлөөлөгч "НОМА" ХХК (цаашид "Төлөөлөгч" гэх), (хамтад нь "Талууд" гэх) нь харилцан тохиролцсоны үндсэн дээр Монгол Улсын Эрүүл мэндийн салбарын эмч, мэргэжилтэнг БНСУ-д сургалтанд хамруулах ажлыг үр дүнтэй зохион байгуулахад Талуудын хооронд үүсэх эрх, үүрэг, хариуцлагыг зохицуулахаар энэхүү гэрээг байгуулав.

Гэрээний хугацаа 2017 оны 06 дугаар сарын 01 өдрөөс эхлэн 2017 оны 12 дугаар сарын 15 өдөр хүртэлх хугацаанд үргэлжилнэ.

### 2. Төлөөлөгчийн үүрэг хариуцлага

- 2.1 Төлөөлөгч нь сургалтанд хамрагдаж байгаа эмч, мэргэжилтэнг хүлээн авах, сургалтыг чанартай зохион байгуулах,
- 2.2 Төлөөлөгч нь сургалтанд хамрагдаж байгаа эмч, мэргэжилтэнг суралцах хугацаанд байрлах байр, хоол, онгоцны буудлаас тосох, хүргэх асуудлыг хариуцах,
- 2.3 Төлөөлөгч нь Монгол Улсаас суралцагчдад сургалтанд хамрагдсан гэрчилгээ олгох,
- 2.4 Төлөөлөгч нь суралцах хугацааны хөтөлбөрийг ЭМХТ-өөс гаргуулан "ПУНДААН ЧА" Төв эмнэлэгт шилжүүлэх,
- 2.5 Төлөөлөгч нь сургалтанд хамрагдах эмч, мэргэжилтний сургалтанд хамрагдах урилга, БНСУ-д зорчих визийн материалыг бүрдүүлэх, Элчин сайдын Яаманд хүргүүлэх,
- 2.6 Төлөөлөгч нь сургалтыг доорх хуваарийн дагуу хариуцан ажиллана.

- 2.6.1 Сургалт 2017 оны 06 сарын 01-ээс 2017 оны 12 сарын 15-ыг дуустал үргэлжлэх бөгөөд энэ хугацаанд туршлага судлах сургалтанд ЭМХТ-өөс батлагдсан хуваарийг үндэслэн үе шаттайгаар хамруулна.

### **3. ЭМХТ-ийн үүрэг хариуцлага**

- 3.1 ЭМХТ нь туршлага судлах сургалтанд хамрагдах эмч, мэргэжилтний холбогдох чиглэлийг урдчилан тодорхойлж хамруулна.
- 3.2 ЭМХТ нь сургалтанд хамрагдах эмч, мэргэжилтэнтэй сургалтын гэрээ байгуулах,
- 3.3 ЭМХТ нь сургалтанд хамрагдах эмч, мэргэжилтний мэдээллийг Төлөөлөгчид урьдчилан хүлээлгэн өгөх,
- 3.4 ЭМХТ нь сургалтын хугацаанд баримтлах сургалтын нэгдсэн удирдамж боловсруулах,
- 3.5 ЭМХТ нь суралтанд хамрагсадын онгоцны тийз захиалах ажлыг хариуцах,

### **4. Төлбөр, тооцоо**

- 4.1 Эмч, мэргэжилтний сургалтыг зохион байгуулах зардал нь нэг хүний /хүн хоног нь 111,800 KRW /нэг зуун арван нэгэн мянга найман зуун вон/-той тэнцэх хэмжээний төгрөг байна. Сургалтанд хамрагдах хүний тоо хугацааг тухай бүр хавсралтаар тохиролцно. Сургалтанд шаардагдах зардлыг гэрээний дагуу "НОМА"ХХК-ийн дансанд тухайн өдрийн Монгол Банкны ханшаар бодон шилжүүлэх буюу ЭМХТ-ийн кассаар баримт үйлдэн шилжүүлнэ.
- 4.2 Сургалтын зардалыг хавсралтын дагуу гэрээний 4.1-т заагдсанаар бодон нийт үнийн дүнгийн урдчилгаа 50 хувийг шилжүүлнэ, сургалтанд хамрагдах тухай тушаал, шийдвэр гарснаас хойш ажлын 3 өдөрт багтаан үлдсэн 50 хувийн төлбөрийг шилжүүлж тооцоо хийнэ.
- 4.3 ЭМХТ нь энэхүү гэрээний дагуу үргэлжлүүлэн суралцах захиалга өгсөн тохиолдолд дээрх үнийг баримтлана.


### **5. Бусад зүйл**

- 5.1 Гэрээнээс үүдэлтэй аливаа маргаан гарвал Талууд хэлэлцээрийн замаар шийдвэрлэх боломжит бүхий л арга хэмжээг авна. Хэрэв уг арга хэмжээ нь зохих үр дүнд хүрэхгүй бол хуульд заасны дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

5.2 Гэрээнд талууд тохиролцон бичгээр нэмэлт өөрчлөлт оруулж болно.


5.3 Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэх бөгөөд эхүүд нь нэгэн адил хүчинтэй байна.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

ЭМХТ-ийг ТӨЛӨӨЛЖ:  
ЭМАХА-НЫ ДАРГА  
  
З.НАРАНБААТАР

Хаяг: СБДүүрэг 1-р хороо Энхтайвны  
13в  
Утасны дугаар: 976-11-70128801  
Факс: 976-320633 9086331

НОМА ХХК-ныг ТӨЛӨӨЛЖ:  
ЗАХИРАЛ



Хаяг: Чингэлтэй Дүүрэг 6-р хороо 6-р  
хороолол 16-31 тоот  
Утасны дугаар: 976-91010806